



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Налайх дүүргийн Суврага Налайх ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/226/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга: Г.Нандинжаргал  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [nandinjargalg@audit.gov.mn](mailto:nandinjargalg@audit.gov.mn)  
Санхүүгийн аудитын албаны ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 11315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: С. Гантөгс  
Утас: 11315558 Цахим хаяг: [gantugss@audit.gov.mn](mailto:gantugss@audit.gov.mn)  
Авера аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Нарантуяа  
Утас: 99133545 Цахим хаяг: [avera.audit@gmail.com](mailto:avera.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ .....	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 696  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН  
СУВРАГА НАЛАЙХ ӨЭМТ-ИЙН  
ДАРГА Б.ДИНАРА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Налайх дүүргийн Суврага Налайх ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ

Нийслэлийн Налайх дүүргийн Суврага Налайх ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн Налайх дүүргийн Суврага Налайх ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 607.2 сая төгрөгийн санхүүжилт авч орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Налайх дүүргийн Суврага Налайх ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 18.5-аар баталж, тайлант онд 16.5 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

C:\User\marangia\Desktop\2025\20250313\20250313\_2025.docx 1426050594

Тус ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамж, 94.7 хувь, ЭМДЕГ-аас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний биелэлт 98.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	41,590,764.25	69,911.85
1.1.2	Дансны авлага	12,244,728.48	7,926,822.50
1.1.6	Бараа материал	64,910,291.08	62,765,826.19
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>118,745,783.81</b>	<b>70,762,560.54</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө (цэвэр)	141,866,723.43	130,603,279.65
1.2.2	Биет бус хөрөнгө (цэвэр)	928,125.00	618,750.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>142,794,848.43</b>	<b>131,222,029.65</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>261,540,632.24</b>	<b>201,984,590.19</b>
2.1.1	<b><u>Богино хугацаат өр төлбөр</u></b>		
2.1.1.2	Цалингийн өглөг	-	24,637.00
2.1.1.3	Татварын өглөг	-	5,035,409.38
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	371,227.75
<b>2.1.1.13</b>	<b><u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u></b>	<b>-</b>	<b>5,431,274.13</b>
<b>2.1.2</b>	<b><u>Урт хугацаат өр төлбөр</u></b>	<b>-</b>	<b>-</b>
2.2	<b>Өр төлбөр нийт дүн</b>	<b>-</b>	<b>5,431,274.13</b>
2.3	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>-</b>	<b>-</b>
2.3.1	Өмч-төрийн	44,040,018.00	44,040,018.00
2.3.9	Хуримтлагдсан үр дүн	199,684,774.24	152,513,298.06
2.3.10	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,815,840.00	-
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>261,540,632.24</b>	<b>196,553,316.06</b>
2.4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>261,540,632.24</b>	<b>201,984,590.19</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1	<b>Борлуулалтын орлого</b>	668,029,424.13	607,242,964.00
2	<b>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</b>	-	
3	<b>Нийт ашиг</b>	<b>668,029,424.13</b>	<b>607,242,964.00</b>
5	Хүүний орлого	-	23,320.98
8	Бусад орлого	-	9,567,852.00
10	Ерөнхий удирдлагын зардал	586,709,351.34	681,782,311.23
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	437,577.18	39,141.82
18	<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>80,882,495.50</b>	<b>(64,987,316.18)</b>
19	Орлогын албан татварын зардал		
20	<b>Тайлант жилийн татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>80,882,495.50</b>	<b>(64,987,316.18)</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>	-	-
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>		

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025.01.01.	2025.12.31.
1	<b>1.Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>620,190,897.14</b>	<b>621,128,721.98</b>
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	617,921,621.65	611,560,869.98
1.1.6	Бусад орлого	2,269,275.49	9,567,852.00
1.2	<b>1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>572,537,394.73</b>	<b>648,023,085.36</b>
1.2.1	Ажиллагсад төлсөн мөнгө	413,612,328.14	453,545,767.34
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	52,010,533.64	51,963,210.04
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	104,986,032.95	67,537,069.00
1.2.5	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө		7,987,405.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	-	39,275,539.53
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	1,428,500.00	385,560.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	500,000.00	27,328,534.45
1.3	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>47,653,502.41</b>	<b>(26,894,363.38)</b>
2	<b>2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>2.1 Мөнгөн орлогын дүн</b>	-	<b>3,068,519.98</b>
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	3,045,199.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	23,320.98
2.2	<b>2.2 Мөнгөн зарлагын дүн</b>	<b>20,949,900.00</b>	<b>17,695,009.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	20,949,900.00	14,649,810.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	3,045,199.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(20,949,900.00)</b>	<b>(14,626,489.02)</b>
3	<b>3.Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>3.1 Мөнгөн орлогын дүн</b>	-	-
3.2	<b>3.2 Мөнгөн зарлагын дүн</b>	-	-

Нийслэлийн Налайх дүүргийн Суврага Налайх ӨЭМТ-ийн 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>26,703,602.41</b>	<b>(41,520,852.40)</b>
6	<b><i>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i></b>	<b>14,887,161.84</b>	<b>41,590,764.25</b>
7	<b><i>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i></b>	<b>41,590,764.25</b>	<b>69,911.85</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт
1	<b>2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл</b>	<b>44,040,018.00</b>	-	<b>17,815,840.00</b>	-	<b>118,802,278.63</b>	<b>180,658,136.63</b>
4	Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	<b>80,882,495.61</b>	<b>80,882,495.61</b>
8	<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>44,040,018.00</b>	-	<b>17,815,840.00</b>	-	<b>199,684,774.24</b>	<b>261,540,632.24</b>
10	Залруулагдсан үлдэгдэл	<b>44,040,018.00</b>	-	<b>(17,815,840.00)</b>	-	<b>217,500,614.24</b>	<b>261,540,632.24</b>
12	Тайлант хугацааны цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(64,987,316.18)	(64,987,316.18)
15	<b>2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>44,040,018.00</b>	-	-	-	<b>152,513,298.06</b>	<b>196,553,316.06</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 160,230.0 мянган төгрөгийн 7 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж баталгаажуулсан. Үүнд:

- Санхүү байдлын тайлан дахь өмнөх оны 82.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг илүү тайлагнасныг залруулав.
- Орлогын дэлгэрэнгүй тайланд 9,591.2 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасныг залруулав.
- Орлогын дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгө данснаас хассан гарзыг 39.1 мянган төгрөгөөр дансны ангилал зөрүүтэй тайлагнасныг залруулав.
- Мөнгөн гүйлгээний тайланд тайлант хугацааны татаас санхүүжилтийн орлогыг 101,991.6 мянган төгрөгөөр ангилал зөрүүтэй тайлагнасныг залруулав.
- Мөнгөн гүйлгээний тайланд 3,709.1 мянган төгрөгийн орлого зарлагыг дутуу тайлагнасныг залруулав.
- Мөнгөн гүйлгээний тайланд бараа материалыг 36,716.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгийг 8,100.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулав.

Энэ нь НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлагналын “*толилуулга ба тодруулга*”, “ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 150.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 150.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

#### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт-1:* Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон (46,716.7 мянган төгрөг) хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоож дахин үнэлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2-т “*илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "толилуулга ба тодруулга", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Элэгдлээрээ анхны өртгөө нөхөж үлдэх өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлэх хүсэлтийг НӨХГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх зөвлөмж өгөв

### Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт 1:** Байгууллагаас олгосон тусламж дэмжлэгээс 150.0 мянган төгрөгийн татвар суутгаагүй байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна:" 7.1.1-д "ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого;" заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "толилуулга ба тодруулга", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Татварын хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэгжүүлж, байгууллагаас олгож буй тусламж дэмжлэгээс татвар суутгах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүү байдлын тайлан дахь өмнөх оны 82.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг илүү тайлагнасан байна.	1	82.5	0	0	1	82.5	1	82.5	0	0	0	

Орлогын дэлгэрэнгүй тайланд 9,591.2 мянган төгрөгийн орлогыг ангилал зөрүүтэй тайлагнасан байна	1	9,591.2	0	0	1	9,591.20	1	9,591.2	0	0	0	0
Орлогын дэлгэрэнгүй тайланд үндсэн хөрөнгө данснаас хассан гарзыг 39.1 мянган төгрөгөөр дансны ангилал зөрүүтэй тайлагнасан байна.	1	39.1	0	0	1	39.1	1	39.1	0	0	0	0
Мөнгөн гүйлгээний тайланд тайлант хугацааны татаас санхүүжилтийн орлогыг 101,991.6 мянган төгрөгөөр ангилал зөрүүтэй тайлагнасан байна	1	101,991.6	0	0	1	101,991.6	1	101,991.6	0	0	0	0
Мөнгөн гүйлгээний тайланд 3,709.1 мянган төгрөгийн орлого зарлагыг дутуу тайлагнасан байна.	1	3,709.1	1	3,709.1	0	0	1	3,709.1	0	0	0	0
Мөнгөн гүйлгээний тайланд бараа материалыг 36,716.5 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	36,716.5	0	0	1	36,716.5	1	36,716.5	0	0	0	0

Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгийг 8,100.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	8,100.0	1	8,100.0	0	0	1	8,100.0	0	0	0	0
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>160,230.0</b>	<b>2</b>	<b>11,809.1</b>	<b>5</b>	<b>148,420.9</b>	<b>7</b>	<b>160,230.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

**/мянган төгрөгөөр/**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй болсон (46,716.7 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлээгүй байна.	1	-					1	-		
Байгууллагаас олгосон тусламж дэмжлэгээс 150.0 мянган төгрөгийн татвар суутгаагүй байна.	1	150.0					1	150.0		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>150.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>150.0</b>		